

**“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024.04.29

Дугаар 01

Улаанбаатар хот

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Махатма Гандийн гудамж 39, Корпорэйт конвеншн центрийн “Эвэнт холл” танхимд 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 9 цагаас хосолсон хэлбэрээр 94.50 хувийн ирцтэйгээр эхлэв.

Хурлын дарга:

Б.Тэлмүүн – ТУЗ-ийн дарга

Хуралд оролцсон:

Б.Ганбат – ТУЗ-ийн гишүүн
Г.Золбоо – ТУЗ-ийн гишүүн
Л.Сонор – ТУЗ-ийн гишүүн
М.Батжаргал -ТУЗ-ийн хараат бус гишүүн

Хурал зохион байгуулах комисс

Комиссын дарга:

Д.Сугар – Тэргүүн дэд захирал

Комиссын орлогч дарга:

Э.Хангай – Засаглалын албаны ахлах хуульч

Комиссын гишүүд:

Э.Уянга – ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Б.Амарсанаа – Хуулийн газрын захирал
Г.Энхтамир – МТГ-ын захирал
Г.Содонбаатар – МОНХГ-ын захирал
Н.Энх-Амгалан – ДАГ-ын МТАТХ-ийн захирал
Г.Баясгалан-ЗА-ны ахлах мэргэжилтэн
С.Билэгсайхан-МТГ-ын ХХ-ийн программ зохиогч
С.Оюун-Эрдэнэ – ХЗГ-ын дилер

Комиссын нарын бичгийн дарга:

Хурлын тооллогын комисс

Комиссын дарга:

А.Батмөнх – ДХШГ-ын захирал

Комиссын гишүүд:

Ц.Дамдинсүрэн – ЭУГ-ын захирал
Д.Жадамбаа – ХЗГ-ын захирал
Б.Цэндсүрэн – МТГ-ын ХХ-ийн захирал
С.Баярхүү – ДХШГ-ын ахлах хянан шалгагч
Л.Булгаа – ХҮА-ны менежер

Комиссын нарийн бичгийн дарга:

ХЭЛЭЛЦСЭН нь:

ТАНИЛЦАХ АСУУДАЛ:

1. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
2. “Төрийн банк” ХК-ийн ногдол ашиг хуваарилалтын тайлангийн танилцуулга;
3. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл.

СОНССОН нь:

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Сайн байцгаана уу. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танхимаар болон цахимаар оролцож буй нийт хувьцаа эзэмшигч нартаа энэ өдрийн мэндийг хүргэе. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2024 онд 4-р сарын 8-ны өдрөөр бүртгэлийн өдрийг тасалбар болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн бөгөөд “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлэгчдийг танилцуулбал Сангийн яаманд 49.26 хувь, Хадгаламж даатгалын корпорацад 45.03 хувь, олон нийт 5.71 хувийг тус тус эзэмшиж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн мэдээг танилцуулъя. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоол. 2024 оны 4-р сарын 29-ний өдөр №1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүчин төгөлдөр болсныг батлах тухай. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт 2024 оны 4-р сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн тогтоох нь, “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй нийт 755,096,250 ширхэг хувьцаанаас тус хуралд саналын эрх бүхий 713,529,079 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноор нийт саналын эрхтэй хувьцааны 94.50 хувь болж байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болсныг үүгээр баталсугай. “Төрийн банк” ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 3-р сарын 18-ны өдрийн 16-р тогтоолын 6-р хавсралтаар баталсан Тооллогын комиссын үүргийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагааг албан ёсоор удирдан нээж өгнө үү хэмээн “Төрийн банк” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн таныг тайзнаа урьж байна.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Эрхэм хувьцаа эзэмшигч хатагтай, ноёд, Төрийн банкны ажилтнууд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Бид 2023 онд хувьцаа эзэмшигч, харилцагч, бизнесийн хамтрагч нарын эрэлт

хэрэгцээнд нийцүүлэн байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжих, бойжуулахад чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллаа. Өнгөрсөн онд банкны нийт зээлийн багц 2.4 их наяд төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 4.8 их наяд төгрөг, актив 5.4 их наяд төгрөгт тус тус хүргэж, татварын дараах байдлаар 94.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж нийт цэвэр ашгийн 50 хувь буюу 48.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тайлант онд хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилан ажиллалаа. Төрийн банк нийгмийн дундаж давхаргыг дэмжигч, бойжуулагч банк байх стратегийн зорилтын хүрээнд ажиллахдаа тулгарсан сорилт, шалгуур бүхнийг хамтын хүчээр туулан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэн ажилласнаар санхүүгийн эерэг үзүүлэлтийг дахин үзүүлж, 2023 оны үйл ажиллагааны үр дүнд банк, санхүүгийн системд эзлэх байр сууриа хамгаалан ажиллаж, Санхүүгийн боловсролыг дэмжигч шилдэг банк, Төрийн өмчит ТОП 4 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарч, улмаар Монголын Хөрөнгийн биржийн ТОП-20 индекст багтаад байна. Төрийн банк 2023 онд НҮБ-ын Даян дэлхийн гэрээ болон Нидерландын нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэлд гишүүн байгууллагаар элсэн орсон бөгөөд санхүүгийн салбарт тогтвортой хөгжил, хариуцлагатай бизнесийн туршлагыг түгээн, оролцогч талуудын ил тод байдлыг хангах, хүлэмжийн хийн ялгарлыг олон улсын аргачлалын дагуу тооцож, тайлагнах, уур амьсгалтай холбоотой шилжилтийн эрсдэлийг удирдах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг байгальд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан нийгэм, эдийн засаг, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх Парисын хэлэлцээртэй уялдуулахад дэмжлэг үзүүлэхээр зорин ажиллаж байна. Төрийн Банк нь банкны салбарын зохистой бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн, Монголбанкны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажиллаж байгааг хэлэхэд таатай байна. Үүний зэрэгцээ хувьцаа эзэмшигч, харилцагч, бизнесийн хамтрагч, ажилтан та бүхний нягт хамтын ажиллагааны үр дүнд бидний санхүүгийн үр дүн эерэг үр дүнтэй гарч энэ чиглэлээр биднийг тууштай дэмжин, итгэл үзүүлж байдагт чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлэхэд таатай байна. Улс орныхоо хөгжлийн үндсэн суурь, тулгуурын нэг болсон банктай ажил, амьдралын зам мөрөө холбосон хувьцаа эзэмшигч, харилцагч, бизнесийн хамтрагч, ажилтан та бидний ашиг, орлого улам бүр арвижиж, ажил үйлс бүхэн тань өргөжин хөгжихийн ерөөл дэвшүүлье. Төрийн банк хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагааг нээснийг үүгээр мэдэгдье. Хурлын индэрт Төрийн банкны удирдлагын багыг урьж байна. Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Төрийн банкны ТУЗ-ийн гишүүд, удирдлагын багийн хамт олон бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож байгаа. Та бүхэнд хурлын хөтөлбөрийг танилцуулъя. Дэлгэц дээр хурлын хөтөлбөр гарсан байна. Хурлын хөтөлбөрт нийт танилцах 3 асуудал, хэлэлцэх 1 асуудал байгаа. 1 дүгээрт, Гүйцэтгэх захирал Ө.Гантөр болон миний бие 2023 оны банкны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулна. 2 дугаарт, “Төрийн банк” ХК-ийн Ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна. 3 дугаарт, “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2023 оны санхүүгийн

үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулна. Үүний дараа Тооллогын комиссоос хурлаар хэлэлцэх асуудлаар хэрхэн санал өгөх талаар зааварчилгааг танилцуулна. Үүний дараа хэлэлцэх асуудал болох Төрийн банкны 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийг танилцуулан хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүний дараа хуралд оролцогчдоос асуулт, хариулт санал явна. Ингээд 10 цаг 05 минутаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалт явагдана. Тэгээд 20 минутын завсарлага байна. 10 цаг 30-аас санал хураалтын үр дүн нэгтгэн танилцуулна. 10 цаг 35 минутаас хурлын шийдвэрийг танилцуулж хурлыг 10 цаг 40 минутад хаахаар төлөвлөж байна. Хурлын хөтөлбөрийн дагуу хурлын үндсэн үйл ажиллагаандаа оръё. Эхний танилцах асуудал буюу Төрийн банк ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулгыг хийнэ үү хэмээн Төрийн банкны Гүйцэтгэх захирал Ө.Гантөрийг индэрт урьж байна.

Нэг. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төрийн банкны нийт хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргэе. Бид хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа өнөөдөр зохион байгуулж байна. 2023 оны Төрийн банкны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг товч байдлаар танилцуулъя. Бид бүхэн 2021 онд дундаж давхаргыг дэмжигч банк болсон. Энэ ажлын хүрээнд Төрийн банк дотооддоо маш олон ажлыг хийж, маш олон бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагч нартаа зориулж гарган ажилласан. Алсын хараагаа бид дундаж давхаргыг дэмжигч үндэсний тэргүүлэгч банк байна гэж тодорхойлж, эрхэм зорилгоо Харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжих, бойжуулахад чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлнэ гэж тодорхойлсон. ТУЗ-ийн 2023 оны 27-р тогтоолоор шинэчлэн баталсан бүтэц зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал, Дэд захирал, 17 газар, 22 хэлтэс, 10 алба, БНСУ дахь төлөөлөгчийн газар нэг, Улаанбаатар хотод 83 нэгж, Орон нутагт 413 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Улсад гадаадад төлөөлөгчийн газартай 2 банк байдаг. Хаан банк болон Төрийн банк. Төрийн банкны төлөөлөгчийн газар БНСУ-д 6 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Системийн хэмжээнд 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт 3,353 ажилтан ажиллаж байна. Үүний 2005 ажилтан орон нутагт, Улаанбаатар хотод 711 ажил, Банкны төв дээр 637 ажилтан тус тус ажиллаж байна. Үндсэндээ нийт ажилтнуудын дийлэнх хувь салбар нэгж дээр ажиллаж байна. Төрийн банк 2022 онд хувьцаагаа Монгол Улсын хөрөнгийн биржид гаргаснаар нээлттэй хувьцаат төрийн өмчит ААН болж 5.71 хувь буюу тухайн үедээ 25.4 тэрбум төгрөгийг босгож чадсан. Энэхүү хөрөнгөөрөө бид дундаж давхаргыг дэмжих зорилгын хүрээнд тодорхой бүтээгдэхүүнүүдэд санхүүжилт болгож гаргасан байгаа. 2023 онд ололт амжилтын хувьд танилцуулахад 2023 оны Санхүүгийн боловсролыг дэмжигч банк, ТОП-10 төрийн өмчит аж ахуйн нэгжийн гуравдугаарт, Дэлхийн хуримтлалын өдөр 2023 аянд амжилттай оролцон Тэргүүн байрт тус тус шалгарсан. 2023 оны эцсээр 94.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласнаар улсын төсөвт

48.0 тэрбум төгрөгийн татвар төлснийг үнэлэн Татварын ерөнхий газраас талархал хүртсэн. Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журмын шалгуур үзүүлэлтийг хангаж ТОП-20 индексийн жагсаалтад багтан ажилласан. Бид бүхэн зах зээл эзлэлтээ нэмэгдүүлэх үйл ажиллагаагаа тэлэх зорилгын хүрээнд эх үүсвэрийг дотоод болон гадаадаас бага хүүтэйгээр татах зорилго тавьж ажиллаж байгаа. Үүний хүрээнд Америкийн Нэгдсэн Улсын Cargill Financial Services International Inc байгууллагаас 55.0 сая ам.доллар, Нидерланд улсын Frontier Clearing Corporation B.V.-аас 30.0 сая ам.долларын эх үүсвэрийг тус тус татан төвлөрүүлсэн. Гялсбанкны 3.0 хувилбар шинэчлэгдэж, 4 төрлийн цахим зээлийг 100 хувь онлайнаар авч, виртуал картаа цахимаар нээж төлбөр тооцоонд ашиглахад хялбар боллоо. Кибер аюулгүй байдлын тухай хууль-д нийцүүлэн Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, 35 ажил бүхий Эрсдэл бууруулах төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. CAELS аргачлалаар банкуудын рейтингийг шинэчлэн тогтооход системийн нөлөө бүхий банкуудаас дөрөвдүгээрт эрэмбэлэгдсэн ба 2022 онд 1.98 сайн үнэлгээ, 2023 онд 1.86 сайн үнэлгээ авч үнэлгээг сайжруулан ажилласан. Үндсэн системийн өгөгдлийн санг Oracle 11 хувилбараас Oracle 19 хувилбарт шилжүүлэх NES системийн сайжруулалт хийх төслийг гүйцэтгэв. Энэ хүрээнд их хэмжээний мэдээллийг Data Warehouse өгөгдлийн сан руу зөөх автомат ажилбар тохирууллаа. Санхүүгийн үзүүлэлтийн хувьд нийт актив тогтмол өсөлттэй буюу сүүлийн 3 жилийн дундаж өсөлт 15.87 хувь байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар 5.3 их наяд төгрөгт хүрсэн. Активын өгөөжийн хувьд 2.31 хувьтай байгаа. Сүүлийн 3 жилийн хугацаанд дунджаар 2 хувьтай байна. Эх үүсвэр татах ажлыг нийт газар, хэлтэс, салбар нэгжүүд чиг үүргийн дагуу амжилттай хэрэгжүүлж байгаа. Дундаж өсөлт 15.67 хувьтай байна. Оны эцсийн байдлаар 4.8 их наяд төгрөгт хүрсэн байна. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө депозит маань хадгаламж болон харилцах хэлбэрээр байгаа. Үүний 99 хувь нь иргэдээс татсан эх үүсвэр байдаг. Актив талдаа нийт зээлийн 88 хувь нь иргэдэд зориулсан зээлийн бүтээгдэхүүн буюу хэрэглээний зээл, малчны зээл, ХАА-н зориулалттай мөн орон сууцын ипотекийн зээлийн бүтээгдэхүүн байгаа. Зээлийн багц оны эцсийн байдлаар 2.4 их наяд төгрөгт хүрсэн байна. 2023 онд давхардсан тоогоор 1,277,662 харилцагчид 2,766.9 тэрбум төгрөгийн зээл олгосон. Оны эцсийн байдлаар 94.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Сүүлийн 3 жилийн дундаж өсөлт 53.2 хувьтай байна. Өөрийн хөрөнгийн өгөөж 18.9 хувьтай байна. Монголбанкнаас зохистой харьцааны шаардлага тавьдаг. Үүнийг Төрийн банк сар болгон биелүүлж тайлагнадаг. Тайлангийн хариугаар Монголбанкнаас зохистой харьцааг бүрэн хангаж ажиллаж байна гэдэг хариуг тогтмол хүргүүлж байгаа. Үүн дотор хамгийн гол 2 үзүүлэлт байдаг. Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 12 хувь байхаас 21.6 хувьтай, төлбөрт түргэн гүйцэтгэх чадвар буюу 25 хувь байхаас 45.7 хувьтай явж байна. 2023 онд “Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу 3 төлбөр хариуцагчид хамаарах 27.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй чанаргүй активыг зээлд учирч болзошгүй эрсдэлийн сангаас хорогдуулан бүртгэж, 1 төлбөр хариуцагчид хамаарах 772.4 сая төгрөгийн авлагыг тэнцлээс хасаж бүртгэсэн байна. 2023 онд нэлээн олон шинэ бүтээгдэхүүн гаргасан. Үүнээс зарим бүтээгдэхүүнүүдийг танилцуулъя. Гялс 3 хувилбарыг

шинэчилж нэвтрүүлсэн ба 4 зээлийн бүтээгдэхүүн буюу Цалингийн цахим зээл, Тэтгэврийн цахим зээл, Гялс зээл, ПОС-ын орлого барьцаалсан зээл Гялс банкаар дамжуулан авах боломжийг бүрдүүлсэн. Хувийн тэтгэврийн сан хадгаламж, Эрүүл иргэн картыг шинээр нэвтрүүлсэн. Эрүүл иргэн картын хувьд Монгол Улсад болон БНСУ-д улсад үйл ажиллагаа явуулж байгаа 3 эмнэлгээр хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн. Малчны зээлийн хэмжээг нэмж, хугацааг нь уртасгасан байгаа. Гадаадад ажиллаж амьдарч байгаа Монгол улсын иргэддээ эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц хөнгөлөлттэй зээлээр авах боломжийг бүрдүүлсэн. Мөн Банкны системд АТМ-ийн төхөөрөмжөөр бэлэн мөнгө өгөх үйлчилгээг Худалдаа хөгжил болон Голомт банк, Капитрон банкттай хамтарч бэлэн мөнгө авсан тохиолдолд шимтгэлийг нь тодорхой хэмжээгээр бууруулах боломжийг бүрдүүлж ажилласан. Төрийн банкны хувьд 2018, 2019 оноос тогтвортой хөгжлийн чиглэлээр бүтээгдэхүүн үйлчилгээг шинэчилж гаргасан. Өмнө нь нэг ажилтан давхар хариуцдаг байсан бол өнөөдөр тогтвортой хөгжлийн алба, тогтвортой хөгжлийн хороог шинээр байгуулж бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагч нартаа санал болгоод явж байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд бид бүхэн жил болгон үйл ажиллагаа зохион байгуулдаг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс санаачилсан Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 44 нэр төрлийн 6,586 ширхэг мод тарьсан. Санхүүгийн боловсролыг харилцагч хадгаламж эзэмшигч нартаа мөн 10 жилийн сурагч, оюутнуудад олгож байна. Орон даяар нийт 7440 га талбайд гялс цэвэрлэгээ хийж ажилласан байна. Эко картыг гаргасан байна. 2023 онд 10 аймаг, 2 дүүрэгт харилцагчийн өдөрлөгийг зохион байгуулж харилцагч нартаа бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож ажилласан байна. За Төрийн банкны үйл ажиллагаа санхүүгийн тайлангийн талаар товч танилцуулгыг танилцууллаа. Одоо Төрийн банкны ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулна.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Одоогийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн 2022 оны 6 сараас хойш үйл ажиллагаагаа явуулан ажиллаж байна. Энэ хугацаанд Төрийн банк нээлттэй ХК болох, Төрийн банк нээлттэй ХК болсонтой холбогдуулан шилжилтийн өөрчлөлтийг удирдах засаглалын шинэчлэлтийг бодитоор хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр Компанийн тухай хууль Банкны тухай хууль, Банкны дүрэмд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. ТУЗ нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгаа. Энд бол Хууль эрх зүй, банк санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн ТУЗ үйл ажиллагаагаа явуулдаг. За үүнээс одоогийн байдлаар 2 гишүүн өөр ажилд шилжсэнтэй холбоотойгоор ТУЗ-ийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдөхөөр байгаа. ТУЗ-ийн даргаар миний бие Б.Тэлмүүн Сангийн яамны төсвийн бодлогын газрын даргаар ажилладаг. ТУЗ-ийн гишүүнээр ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын даргаар ажиллаж байсан Д.Цолмон нар ажиллаж байсан. Д.Цолмон өөр ажилд шилжсэнтэй холбогдуулаад ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэх шаардлага үүссэн. Мөн Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын даргаар ажиллаж байсан Б.Сүх-Очир өөр ажилд шилжсэн учир ТУЗ-ийн бүрэлдэхүүн шинэчлэгдэх шаардлагатай байгаа. Хараат бус гишүүдийн хувьд Монгол Улсын гавьяат эдийн засагч М.Батжаргал, мөн Д.Энхжаргал,

С.Цэнд-Аюуш гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. ТУЗ нь 2023 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 14 удаа хуралдаж, 57 асуудал хэлэлцэн, 20 шийдвэр, 127 тогтоол батлан ажилласан. Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2022, 2023 онд нийт 198 үүрэг даалгавар өгснөөс 2023 оны байдлаар биелэлт 92 хувьтай байна. 2023 онд бидний хийсэн онцлох ажлуудаас дурдвал Банкны зээлийн багц 2.4 их наяд төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 4.8 их наяд төгрөг, нийт актив 5.4 их наяд төгрөгт хүрч, 2022 оны татварын дараах цэвэр ашгийн 50 хувь буюу 48.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2023 онд хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан. Санхүүгийн боловсролыг дэмжигч шилдэг банк, Төрийн өмчит ТОП 4 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарч, улмаар Монголын Хөрөнгийн биржийн ТОП-20 индекст багтаж, Гялс банкны 3.0 хувилбарыг нэвтрүүлсэн. НҮБ-ын Даян дэлхийн гэрээ болон Нидерландын нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэлд гишүүн байгууллагаар элсэн орсон. Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст нийцүүлэн банкны засаглалын бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн батласан. “Төрийн банк” ХК-ийн ТУЗ-ийн хурлаар 2023 онд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг Сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих журмын дагуу олгож, тус журмын холбогдох заалтад үл хамаарах 2 сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг тусгайлан хэлэлцсэн бөгөөд Төрийн банкны сонирхлын зөрчлийг зохицуулах журамд заасан нөхцөл шаардлагыг хэрэгжүүлж ажилласан. ТУЗ-ийн дэргэд компанийн дүрэмд заасны дагуу Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо гэх 4 хороод ажиллаж байгаа. 3 хорооны даргаар хараат бус гишүүн ажиллаж байгаа. 2023 онд Аудитын хороо нийт 14 удаа хуралдаж, 42 асуудал хэлэлцэн, 38 шийдвэр гарсан. Эрсдэлийн удирдлагын хороо 9 удаа хуралдаж, 28 асуудал хэлэлцэн, 25 шийдвэр гаргасан. Нэр дэвшүүлэх хороо 6 удаа хуралдаж, 9 асуудал хэлэлцэн, 7 шийдвэр, Цалин урамшууллын хороо 4 удаа хуралдаж, 5 асуудал хэлэлцэн 4 шийдвэр тус тус гаргасан байна. ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газар банкны үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичиг, банкны бодлого, журам, зааврын хэрэгжилт, банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангагдаж байгаа эсэхэд хяналт тавих, мөн банкны эрсдэлийн удирдлага, засаглал ба дотоод хяналтын тогтолцоог үнэлж дүгнэх, үйл явцыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, банкны үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлд ажиллаж байна. 2023 онд 27 аудитын ажил хийж, 50 дүгнэлт, 346 зөвлөмжийг гарган ажилласан байна. ТУЗ-ийн 2023 оны 8-р сарын 14-ний өдрийн 80 дугаар тогтоолоор “Төрийн банк” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-тай гэрээ байгуулах зөвшөөрлийг олгон, 2023 оны санхүүгийн тайланд гэрээний дагуу хөндлөнгийн аудит хийлгэсэн. 2023 онд ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалттай холбоотой ажлуудыг хийгдсэн. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хөндлөнгийн оролцоог нэмэгдүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах зорилгоор хараат бус гишүүдийн тоо өмнө нь 3 байсныг 4 болгож тоог нэмэгдүүлсэн. Төрийн төлөөллийн гишүүдийн тоог бууруулсан байгаа. Үүнтэй холбоотойгоор хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг 2-р сарын 20-ны өдрөөс 3-р сарын 5-ны өдрийг дуустал хугацаанд нээлттэй, ил тод зарласан. Харамсалтай нь шаардлага

хангасан 4 гишүүдийн тоо бүрдээгүй тул сонгон шалгаруулалтыг хүчингүй болгосон. Иймээс 2024 оны 4-р сарын 22-ны өдөр хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг дахиж зарласан байгаа. Хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалт амжилттай болсны дараа төрийн төлөөллийн гишүүд, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоох асуудал хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар яригдах төлөвлөгөөтэй байгаа. Та бүхэнд ТУЗ-ийн тайланг танилцуулж дууслаа. Дараагийн 2 танилцуулгыг миний бие дахин танилцуулна.

Хоёр. “Төрийн банк” ХК-ийн ногдол ашиг хуваарилалтын тайлангийн танилцуулга

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна, 46.15 дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана гэж тус тус заасны дагуу 2023 оны 2-р сарын 17-ны өдрийн ТУЗ-ийн 21-р тогтоолоор Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргасан. Тогтоолын дагуу банкны 2022 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж, 2023 оны 4-р сарын 28-ны өдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан. Хуваарилалтын үр дүнгээр 7,867 хувьцаа эзэмшигчдийн 755,096,250 ширхэг энгийн хувьцаанд нэгж хувьцааны үнэ 63.68 төгрөгөөр, нийт 48,084, 529,200 төгрөгийн ногдол ашиг олгосон байна.

Гурав. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны хоёрдугаар сарын 19-ний өдрийн 10 дугаар тогтоолын дагуу банкны 2023 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 66.20 төгрөг буюу нийт 49.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдөр 2024 оны 4-р сарын 8-ны өдөр байсан. Ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар дамжуулан 2024 оны 4-р сарын 22-ны өдөр хувьцаа эзэмшигч нартаа олгосон байна. Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон Төрийн банк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод заасан зохих шаардлагуудыг хангахаар байна. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа. Хөтөлбөрийн дагуу саналаа хэрхэн өгөх талаар Тооллогын комисс тайлбарлана. Тооллогын комиссын дарга А.Батмөнх таныг индэрт урьж байна.

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Тооллогын комисс хурлын заалны зүүн талд байрлаж байна. Саналыг онлайнгаар болон цаасаар авна. Санал хураах явуулын болон шууд газар дээр нь авах хайрцгийг бэлдэн байршуулсан байна. Та бүхэн банкны программаар болон өөрсдийн гар утсаар программдаа нэвтэрч ороод саналын хуудсыг бөглөх заавартай тусгайлан танилцаж болно. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа болон

санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийг программд байршуулсан байгаа. Урьдчилж санал өгсөн хувьцаа эзэмшигч давхардуулж саналаа өгөхгүй. Засварласан, балласан, залруулгатай хоосон бол журмын дагуу саналын хуудас хүчингүйд тооцогдохыг та бүхэн анхаарна уу. Цахимаар санал өгч байвал зөвхөн хэлэлцэх асуудлаар саналаа өгнө. Саналын хуудас дээр санал хүсэлт болон асуух асуулт байвал нэмэлтээр бөглөж болно. Тооллогын комисс хэлэлцэх асуудлын дараа санал хурааж, саналын үр дүнг маш хурдан гаргаад та бүхэндээ танилцуулах болно. Та бүхэн цаасаар санал өгөх бол хурлын танхимд байршиж байгаа саналын хайрцагт хийж болно. Мөн суудал дээрээсээ гараа өргөх юм бол явуулын хайрцагаар саналыг очоод авах бүрэн боломжтой. Хувьцаа эзэмшигч та бүхэн саналаа идэвхтэй өгөхийг хүсье.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: За баярлалаа. Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх 1 асуудал болох “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийн танилцуулгыг миний бие танилцуулна.

Нэг. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Та бүхэнд хэлэлцэх асуудлын материал тараагдсан байгаа. Та бүхний хувьд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд мэдээллээр хангагдсан байгаа. Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт хариултыг хурлын дэгийн дагуу 2 минутаар явуулна. Хуралд биечлэн ирснээс гадна цахимаар оролцож байгаа гишүүдээс асуулт, санал ирж байгааг танилцуулах нь зүйтэй. Та бүхэн асуулт асуухдаа өөрийнхөө нэрийг хэлээд асуултаа асууна уу.

Цэрэнжав, Хувьцаа эзэмшигч: Өнгөрсөн онд хэлэлцсэн жижиг хувьцаа эзэмшигчдийн хувь хэмжээг нэмэгдүүлэх асуудал яригдсангүй. Нэмж хувьцаа гаргах асуудал юу болсон бэ? Их хурлын шийдвэр гарсан. Бид өнгөрсөн жилийн хурлын үед шийдвэр гаргасан гэж бодож байгаа. Мөн цаашаагаа улс орны эдийн засгийн тулгуур болсон хөрөнгийн зах зээл дээр манай банк яаж ажиллаж байна вэ? Бусад банкнуудын үйл ажиллагааг ажиглаад байхад ҮЦК байгуулаад идэвхтэй ажиллаж байгаа харагдах юм. Энэ тал дээр тодорхой ажил хийгдэхгүй байгаа юм болов уу, гэж бодогдож байна.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Банк нэмж хувьцаа гаргахтай холбоотойгоор бэлтгэл ажлууд болон зохион байгуулалтын ажлууд тасралтгүй хийгдээд явж байгаа. Сангийн сайдаас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу нэмж хувьцаа гаргах асуудлыг одоо хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нарын эрх ашгийг аль болох хөндөхгүйгээр өөрөөр хэлэх юм бол хувьцааны үнийг аль болох бууруулахгүй чиглэлээр зах зээлийн нөхцөл байдалд уялдуулан авч үзэхээр ажиллаж байгаа. Нэмж болон одоо байгаа хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар 20 хүртэл хувийн хувьцааг олон нийтэд санал болгохоор ийм чиглэлтэй ажиллаж байна.. Үүн дээр үндсэн гол асуудал нь зах зээлийн нөхцөл

байдалтай холбоотой. Өнгөрсөн онд бүх том банкнууд нээлттэй ХК болсон. Үүнтэй холбоотой Монголын хөрөнгийн зах зээлийн шингээх чадвар, яг энэ макро эдийн засгийн нөхцөл байдал, хүмүүсийн худалдан авах чадвар, хөрөнгө оруулалтын орчинтой холбоотойгоор нэг дор их хэмжээгээр хувьцаа дахиж санал болгосон тохиолдолд одоогийн хувьцааны үнэ эрсдэлд орох, компанийн үнэлгээтэй холбоотой асуудал гарч болзошгүй байгаа. Тэгэхээр энэ ажил бол хийгдэж байгаа. ТУЗ-ийн зүгээс гүйцэтгэх удирдлагад өгсөн үүрэг, чиглэл бол энэ чиглэлээр зах зээлийн судалгаа хийх, үнэт цаасны брокерын болон судалгааны компаниудтай хамтран ажиллах, стратегийн гаднын болон дотоодын хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах, нэмж хөрөнгө оруулагч татах чиглэлээр холбогдох ажлууд тасралтгүй хийгдээд явж байгаа.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төрийн банкны хувьд хөрөнгийн зах зээл дээрээс мэдээж идэвхтэй бол оролцохгүй байгаа. ЗГ-ын бонд болон бусад санхүүгийн чадавхтай компаниудаас гаргасан зарим нэг бондыг худалдаж авч байгаа. Зарим нэг үнэт цаасыг үнэлгээ хийсний үндсэн дээр богино хугацаагаар худалдаж авах ажлыг хийдэг. Бусад банкнуудын хувьд таны хэлж байгаа үнэн, доороо дэргэдээ ч юм уу ҮЦК-тай үйл ажиллагаа явуулж байгаа. Үнэт цаасныхаа компаниар дамжуулаад хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа нь үнэн. Төрийн банкны хувьд бол энэ оны бизнес төлөвлөгөөнд энэ талаар тусгагдаагүй байгаа. Ирэх онд тусгах боломж бололцоо байна уу, үгүй юу, бид хуулиа барих ёстой, харах ёстой. Банкны хувьд өөрийнхөө хувьцаа дээр ямар нэгэн байдлаар хувьцааны үнэ ханшид хууль бусаар нөлөөлөх гэдэг юм уу, үнийг өсгөх гэдэг юм уу ийм арга хэмжээг авах нь хуулиараа хориотой байгаа. Яг зах зээлийнхээ зарчмаар явж байгаа. Төрийн банкны Хөрөнгө зохицуулалтын газар энэ чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Нэмж хариулах зүйл байвал Д.Жадамбаа захирал хариулна уу.

Д.Жадамбаа, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал: 2023 онд гаргах байсан манай нэмэлт хувьцааны асуудал эдийн засгийн нөхцөл байдал, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашигтай холбоотойгоор түр хугацаанд хойшилж байгаа. Зах зээл дээр богино хэмжээнд маш их хэмжээний хувьцаа нийлүүлэгдсэн учраас зах зээл дээр банкнуудын хувьцааны үнэ унаж байгаа. Энэ нөхцөл байдалтай холбоотой хойшлуулсан байгаа. Компани бол доороо охин компани байгуулах боломжгүй байдаг, хуулиараа. Бусад банкнуудын хувьд толгой компаниараа дамжуулаад, зэрэгцээ ҮЦК-иуд байгуулаад ажиллах бүрэн боломжтой, хамтарч зэрэгцээд ажиллах боломж гардаг. Төрийн банкны хувьд ийм боломж байхгүй байгаа.

Мандмаа, Хувьцаа эзэмшигч: Анх удаа Төрийн банкны хувьцаа авсан. Хувьцаатай холбоотой асуудал дээр эргэлзээ төрүүлээд байна. Яагаад гэхээр, би стратегийн хөрөнгө оруулагч, тодорхой хэмжээний мөнгөн дүнг байршуулсан байгаа. Гэтэл хувьцааны үнэ унаад байдаг. Гэтэл та ярилаа, банк хувьцааны үнэ унахад ямар ч зохицуулалт хийх боломжгүй гээд байдаг. Гэтэл энэ хувьцаа аваад мөнгөө тодорхой хэмжээнд байршуулсан хүмүүс эрсдэл үүрээд байна, буцаад зарах болох юм уу, зарна гэхээр буцаад маш их мөнгөний алдагдалд орох гээд байдаг. Тэгэхээр энэ дээр ер нь банк ямар арга хэмжээ авах

юм бол? Хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг гэж өгөөд байгаа чинь жилийн хадгаламжийн хүүгээс нэг их ялгагдахааргүй бараг л тэрнээс давахааргүй байгаад байдаг. Тэгэхээр бид нар хувьцаа авах нь ер нь ашигтай юм уу, ашиггүй юм уу, гэдгээ эцсийн эцэст ойлгохоо больчихоод байгаа. Тэгэхээр энэ талаар ямар арга хэмжээ авах вэ? Бид нарын хувьцааны үнийг бууруулахгүй байх дээр нь ногдол ашгийг хадгаламжийн хүүнээс дээш гаргах боломж юу байдаг юм бол? Тэр талаар асууя.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төрийн банк 2021 онд шинэчлэгдэн батлагдсан банкны тухай хуулийн дагуу 2022 онд олон нийтэд хувьцаагаа санал болгож гаргасны үр дүнд 25.4 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг босгон, банкныхаа үйл ажиллагааг тэлэх зорилгоор үйл ажиллагаандаа зарцуулаад явж байна. Төрийн банкандаа итгэж хувьцаа авч, Төрийн банкны хувь эзэмшигч болсон Та бүхэндээ баярлалаа. Хувьцааны ханшийн хувьд 2022 он болон 2023 онд системийн нөлөө бүхий бусад 4 банк, дээрээс нь зарим нэгэн санхүүгийн компаниудын хувьцаа гаргасантай холбоотойгоор зөвхөн Төрийн банкны ч биш бусад банкнуудын хувьцаа тодорхой хэмжээгээр унасан. Нэг хэсэг унаж байгаад одоо тогтвортой ханшан дээр байна. Бид 2022 он болон 2023 онд нийт ашгийнхаа 50 хувийг ногдол ашигт хуваарилсан байгаа. Ногдол ашгийн өгөөжөөрөө хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудаас нэлээн дээгүүр байгаа гэж үзэж байгаа. Хувьцааны хувьд мэдээж стратегийн хөрөнгө оруулагчийн хувьд урт хугацаандаа өгөөжөө хардаг байх. Тэгэхээр зэрэг 1 юм уу 2 жилийн хугацаанд цаашдаа тогтвортой хувьцаагаа хадгалах нь зөв байх гэж бодож байна. Нэмж хувьцаа гаргахаар судлаад, шинжлээд явж байгаа. Гэхдээ жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хөндөхгүй байх үүднээс үе шаттайгаар гаргах ийм зорилт тавиад ажиллаж байгаа.

Д.Жадамбаа, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал: За нэмж хариулъя. Төрийн банк 2023 онд ашгаараа өөрийн хөрөнгийн өгөөж нь 17 орчим хувьтай байгаа. Үүнээсээ ногдол ашиг хэлбэрээр олгосон маань жишээ нь, 2-р сарын 19-ний хаалтын ханшаар тооцох юм бол 12.5 хувийн өгөөжтэй байсан. Ер нь хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны өгөөжийг аль болох жил болгоныхоо ашгаар дамжуулаад өгөөжөө өсгөөд явах бодлоготой ажиллаж байгаа.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Цахимаар Мөнхжаргал гэж хүнээс санал ирсэн байна. Үүнийг танилцуулчихъя. Цаашид Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорацаас банкны эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч Төрийн болон ТББ-ын эх үүсвэрийг байршуулах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна гэсэн, асуулт санал байна.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: Төрийн банк ХК нэг талдаа ТӨК, нөгөө талдаа бид банкны зах зээл дээр өрсөлдөөний хуулийг баримтлах шаардлагатай. Тэгэхээр төрийн гэсэн байдлаараа зах зээл дээр илүү давуу байдал олж авах хуулийн тодорхой хязгаарлалтууд байдаг. Төрийн болон ТӨК-иас эх үүсвэр татах асуудал нь яг өрсөлдөөний зарчмаар явж байгаа. Сангийн яамнаас яг хууль тогтоомжийнхоо хүрээнд хувьцаа эзэмшигчдийн зүгээс боломжтой бүх дэмжлэгийг үзүүлж байгаа. Анхаарч ажиллах шаардлагатай гэсэн саналыг хүлээж авч байна. За дараагийн цахимаар ирсэн санал, хувьцаа эзэмшигч Алтансүхээс ажилтнуудын цалинг

өрсөлдөхүйц түвшинд тогтоох гэсэн санал ирүүлсэн байна.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Мэдээж ямар ч байгууллагын хамгийн үнэт капитал бол хүний нөөц, ажилтнууд маань байдаг. Төрийн банканд өнөөдрийн байдлаар 3,353 ажилтан, нийт 500 салбар, нэгж дээр ажиллаж байна. Мэргэшсэн чадавхтай, чадалтай ажилтнуудаа тогтоон барих, ажилтнуудынхаа цалинг нэмэх чиглэлээр удирдлагын хувьд үе шаттай арга хэмжээнүүдийг аваад явж байгаа. 2022 оноос хойш ялангуяа гүйлгээний ажилтан, харилцааны менежер буюу эдийн засагчдынхаа цалинг үе шаттай нэмж, зэрэглэл тогтоогоод явж байгаа. Мөн саяхан гол хувьцаа эзэмшигч Сангийн яам, Сангийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу орон нутаг, аймагт ажиллаж байгаа ажилтнуудынхаа цалинг түлхүү нэмэх бодлогыг бариад шийдвэр гаргаад явж байна. Мөн Улаанбаатар хотод ажиллаж байгаа нийт ажилтнуудынхаа цалинг тодорхой хувиар нэмэхээр өнөөдрөөс шийдвэр гараад, олгогдоод явах байх. Зах зээлийн зарчмаараа бид нар цалингийн системээ шинэчлэн тогтоож аль болох бусад банкнуудтай дүйцүүлэх хэмжээнд ажиллана. Энийг нийт хувьцаа эзэмшигч болон ажилтнуудынхаа өмнө удирдлагын хувьд амлаж байна.

Б.Тэлмүүн, ТУЗ-ийн дарга: ТУЗ-ийн зүгээс банкны анхан шатын болон дунд шатны нэгжүүдэд ажиллаж байгаа ажилчдын цалин, хангамж, ажиллах орчинг өрсөлдөхүйц байх дээрээс нь Төрийн банканд ажиллаж байгаа болон одоо хувьцаа эзэмшиж байгаа маш олон ажилтнууд байдаг. Тэдгээрийн банканд ажиллах хугацаандаа бас таатай байх боломжтой бүх дэмжлэгийг үзүүлэхэд анхаарч ажилладаг. Энэ жилийн хувьд ЗГ-аас барьж байгаа төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд бид ялангуяа орон нутагт ажиллаж байгаа анхан шатны нэгжийн ажилтнуудын цалинг нэмэх шийдвэр гаргасан. Цалингийн нэмэгдэл ороод явна гэж ойлгож байгаа.

Наранбаатар, Хувьцаа эзэмшигч: Би 2015 оноос хойш Төрийн банкнаас зээл авч, компанийн үйл ажиллагаагаараа байнга харилцаж ирсэн. Иргэдийн зээлтэй холбоотойгоор нэг асуудал байна. Урьд нь барьцаа хөрөнгийг аятайхан үнэлээд явдаг байсан. Сүүлийн үед барьцаа хөрөнгийг хэт багаар үнэлж байна. Олон жил харьцсан зээл авсан хүмүүстээ таатай нөхцөлийг ерөөсөө тавихгүй байна. Бусад банкнуудын хувьд жишээлбэл төрийн байгууллагатай гэрээ байгуулсан тохиолдолд гэрээ барьцаалсан зээл гэх мэт шинэ юмнуудыг зөндөө гаргаж байна. Өөр банкнуудаас тавьж байгаа аятайхан саналууд байна. Төрийн банкнаас шинэ санал, санаа гарахгүй, дээрээс нь хөрөнгийн үнэлгээг хэт багаар үнэлж байна. Мөн зээлийг зүгээр энгийн иргэн авахад хэцүү болчихоод байна шүү дээ. Бусад банкнуудтай харьцуулахад өрсөлдөхүйц, түргэн хөрвөх чадвар, иргэдэд хүрч ажиллаж байгаа байдал, зээлтэй холбоотойгоор хурдан дүгнэж шийдэж байгаа зэрэг дээр учир дутагдалтай ажиллаж байгаа гэж үзэж байна. Энэ дээр ямар арга хэмжээ авч ажилладаг юм бэ?

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төрийн банкны нийт активын 55-63 хувь нь зээл байдаг. Зээл дотроо түрүүн хэлсэн нийт зээлийн 80 гаруй хувь нь иргэдэд зориулагдсан бүтээгдэхүүн байна. Өөрөөр хэлэх юм бол хэрэглээний зээл, орон сууцны ипотекийн зээл, малчны зээл

үлдэж байгаа 20 орчим хувь нь бизнесийн зориулалттай олгодог зээл байгаа. Төрийн банкны зээлийн бүтээгдэхүүний хувьд бусад банкуудтай өрсөлдөхүйц хэмжээнд санал болгодог гэж ойлгож байгаа. Хэмжээний хувьд бол дээд тал нь 5.0 тэрбум төгрөгийн зээл олгож байгаа. Энэ ч утгаараа Төрийн банк маань иргэдэд хандсан иргэдийн банк юм гэж ойлгож бас болох юм. Нөгөө талдаа банк гэдэг байгууллага бол эх үүсвэр татаад харилцагч, хадгаламж эзэмшигчдийн мөнгийг татан байршуулаад үүнийгээ буцаагаад зуучлалын шугамаар, зуучлалын үйлчилгээ үзүүлж зээл хэлбэрээр бүтээгдэхүүн гаргаж байгаа. Тэгэхээр зээл олгоход мэдээж барьцаатай олгох ёстой. Барьцаа хөрөнгө маань хангалттай үнэлгээтэй байж зээл маань эрсдэлгүй байх ёстой юм. Тэгж байж бид нар харилцагчдын эх үүсвэр мөнгөн хөрөнгийг бүрэн бүтэн байлгах анхны шаардлагаар төлбөр тооцоо хийх бололцоо бүрдэх юм. Тэгэхээр мэдээж банк болгон өөрсдийн дотоод үнэлгээтэй, дотооддоо эрсдэлээ тооцдог байгаа. Төрийн банкны хувьд энэ эрсдэлийг хаах зорилгоор холбогдох журмууд батлагдсан. Үүнийхээ дагуу барьцаа хөрөнгөө үнэлээд зээл олгодог байгаа. Банкны хувьд ЗГ-аас хэрэгжүүлсэн 10 их наяд төгрөгийн хөтөлбөрт амжилттай оролцсон. Нийтдээ 700 орчим тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл, ажлын байр нэмэгдүүлэх зээлийг гаргасан байгаа. Тухайн үед 2021 оноос хойш ажлын байр нэмэгдүүлэх зээлд нийт 442 тэрбум төгрөгийг олгосон. Өнөөдөр энэ зээлийн үлдэгдэл 20 гаруй тэрбум төгрөг буюу эргэн төлөлт маш сайн байгаа. Ажлын байр нэмэгдүүлэх зээлийг олгосноороо бид нар нийтдээ 26 мянган ажлын байрыг тогтоон барьж үлдсэн. Зээл талдаа харьцангуй бас сайн ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Уян хатан байх нөхцөл дээр бол бид нар одоо бас таны саналыг болбол хүлээж авъя. Дэд захирал Х.Лхагвасүрэн захирал нэмэлтээр хариулна.

Х.Лхагвасүрэн, Дэд захирал: Сайн зээлдэгч нартаа, байнгын харилцагч нартаа уян хатан хүү тогтоох тал дээр хэлсэн санал дээр бас нэмэлт бас тайлбар өгье. Банк ерөнхийдөө бол зээлдэгчийнхээ түүхийн үнэлгээг Монголбанкны зээлийн мэдээллийн сангаас ерөнхийдөө авдаг, дээрээс нь банк өөрийн давтан зээлдэгчийн зээлийн дотоод үнэлгээ хийдэг байгаа. Үүн дээр бид нар үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөлөөр тухайн бүтээгдэхүүнийхээ зээлийн дээд, доод хөл тогтоосон байдаг. Зээлдэгч маань өмнө нь манайхаас зээлээ аваад дотоод үнэлгээгээрээ зээлийн түүх нь сайн байх юм болбол бид нар зээлийн хүүг 6 сар тутам 0,1 хувийн пунктээр бууруулах ийм процесс манай дээр болбол мөрдөгддөг. Тэгээд сайн зээлдэгч нар маань болбол ерөнхий нөхцөлийн доод хүүгээрээ зээл авах боломж нь бол нээлттэй байгаа. Бүтээгдэхүүн тус бүрээсээ хамаараад энэ үнэлгээнүүд хийгддэг байгаа гэсэн мэдээллийг өгье. Барьцаа хөрөнгийн үнэлгээний тухайд бол банк өөрийн зээлийн бодлого, эрсдэлийн удирдлагын бодлого дээрээ зээлийнхээ эрсдэлийг яаж хаах вэ, гэдэг дээр тодорхой төрлийн хөрөнгүүд дээр ямар үнэлгээгээр хувь тооцож үнэлгээгээ хийх вэ, гэдэг ийм тогтоосон хязгаарууд байдаг. Энэ маань бас бусад банкнуудын барьцаа хөрөнгийн үнэлгээний хувь хэмжээтэй бол ойролцоо явж байгаа. Хөрөнгийнхөө төрлөөс хамаараад бид нар үнэлгээ хийж байгаа. Үнэлгээний хувьд бол бизнесийн зээлүүд дээр илүү түлхүү барьцаа хөрөнгүүд их хэмжээний дүнтэй зээлүүд дээр барьцаа хөрөнгүүдээр их үнэлэгддэг. Хөдлөх хөрөнгө за бусад хөрөнгүүдийг бид нар бас үнэлдэг байгаа. Тэгэхээр бусад банкнаас бол хэт доогуур үнэлж байна гэдэгтэй болбол санал

нийлэхгүй байна. Яагаад гэхээр бид нар бусад банкнуудынхаа бас барьцаа хөрөнгийн үнэлгээний бодлого, журам дээр Монголын банкны холбоо дээр бас энэ эрсдэлийн мэргэжлийн зөвлөл дээр мэдээлэл солилцоод явдаг учраас энэ дээр бол хэт багаар бас үнэлэхгүй байгаа гэж хэлмээр байна.

Сүрэнхорлоо, Хувьцаа эзэмшигч: Мэдээж компани л юм чинь нийт цэвэр ашгийнхаа тодорхой хувийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгож өгдөг. Тодорхой хувиар нь үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг өргөтгөх, хэрэглэх нь зайлшгүй ээ, ойлгож байна аа. Нэг тодруулах зүйл бол мөнгөн дүнгээр нь харвал нэгж хувьцаа эзэмшигчид олгож байгаа ногдол ашиг нэмэгдэж байгаа. Тэгэхдээ цэвэр ашгийн хэдэн хувийг хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг болгож өгөх тоог тогтоохдоо хөрөнгө тогтоохдоо энэ инфляцын түвшнийг тооцдог тийм юм байна уу, байхгүй юу гэж энийг тодруулж асуумаар байна.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Ногдол ашгийн хувьд бол ерөнхий Компанийн тухай хууль болон банкны дүрэмд бол цэвэр ашгаасаа бол хөрөнгө оруулалт, тухайн жилдээ шаардагдах хөрөнгө оруулалтаа хийгээд үлдэх хувийнхаа бол бид тодорхой хувийг ногдол ашгаар зарлахаар бол шийддэг. УИХ-аас болон Сангийн сайдаас өгч байгаа чиглэлийн дагуу бол яг банканд шаардагатай хөрөнгө оруулалтаа хийгээд үлдэх цэвэр ашгийнхаа 50 хувийг нь буюу одоо яг энэ тогтвортой ногдол ашиг хуваарилах хувийг ийм бодлого баримтлаад явж байгаа. Өнгөрсөн жил болон энэ жилийн хувьд. Үүн дээр бол цэвэр ашгийнхаа 50 хувь гэдэг энэ тоогоороо бол яах бодлого бол баримталж байгаа. Тэрнээс биш бид нар яг энэ ногдол ашгийн хэмжээг инфляцын түвшиндээ уялдуулж тогтмол өсдөг гэдэг ийм бодлогын хувилбарыг одоогоор бол баримтлаагүй байгаа. Ийм ногдол ашгийн бодлого баримтлах бол боломжтой. Гэхдээ УИХ дээр УИХ-аас гаргасан тогтоол болон ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулиар бол ерөнхий цэвэр ашгийн тодорхой хувийг жил болгон ингэж тогтмол барьж байх ийм чиглэлийг бол бид баримтлаад явж байгаа. Яг инфляцын түвшиндээ уялдуулж өсгөх гэсэн ийм хувилбар одоохондоо байхгүй байгаа. Бид нар банкны цэвэр ашиг нэмэгдэх тусам, банкны үйл ажиллагаа сайжрах тусам ногдол ашгийн хэмжээ бол өсөөд явна.

Ганбаяр, Хувьцаа эзэмшигч: Жижиг хувьцаа эзэмшигчдийн нэг байгаа юм. Эхний асуулт, оны ногдол ашгийг тараах хувь хэмжээг одоо тодорхойлж гаргасан уу, байгаа бол төлөвлөгөөнд хэдэн хувиар өгөхөөр байгаа юм бэ? 3 дахь асуулт, ТУЗ-ийн шийдвэрээр бүх захирлуудыг халсан шүү дээ. Халаад, хариуцлага тооцож байх шиг байна. Муу ажилласан гээд, Хаан банкны цэвэр ашгаас 5 дахин бага ажилласан гээд халж байгаа гэж би ойлгосон. Тэгээд тэр хүмүүсийг зүгээр халаад явуулчихаж байгаа юм уу, хариуцлага тооцохгүй юм уу? Дараагийнх нь санал маягийн юм байна. Би дөнгөж сая Гялс 3 шинэ аппликэйшнийг нь татаж үзлээ, паспортоо, нууц үгээ сэргээж үзлээ, 2 удаа код илгээх дарлаа, миний данснаас 2 удаагийн шимтгэл нь хасагдаад, одоо хүртэл надад мессеж нь ирээгүй одоогоор 20 минут болж байна. Танай IT багийнхан бол муу байна шүү, үнэхээр их хэрэггүй байна, яаралтай энэ хүмүүстээ хариуцлага тооц, одоо хүртэл мессеж нь ирээгүй байна, нууц үг сэргээх код

нь. За баярлалаа.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Жил болгон бид нар санхүү болон бизнес төлөвлөгөөгөө болбол өмнөх он нь батлаад явж байгаа. 2024 оны эцсээр болбол 81,3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллана гэсэн, ийм төлөвлөгөөг ТУЗ-өөрөө ороод батлуулаад ингээд үйл ажиллагаагаа явуулж байгаа. Ногдол ашгийн хувьд болбол сүүлийн 2 жил үндсэндээ хөрөнгө оруулалтаа хасаад үлдэж байгаа 50 хувийг нь хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилсан байгаа. Захирлууд халсан гээд нэг юм хэлчих шиг боллоо. Буруу сонсчхов уу, буруу ойлгогчхов уу, Хэмнэлтийн хуультай холбоотой дэд захирлуудын орон тоо байхгүй болсныг хэлж байгаа юм болов уу? Тэгж ойлголоо, би. УИХ-аас баталсан Хэмнэлтийн хуулийн дагуу тухайн үед 5 дэд захиралтай байсан, дэд захирлуудын орон тоог болбол тухайн үед хуулийн дагуу бид нар орон тоог нь байхгүй болгосон, ХК болсноороо тухайн одоо бас хэмнэлтийн хуулийн дагуу Дэд захиралтай болох энэ боломж бүрдсэн. Үүний дагуу болбол Тэргүүн дэд захирал, Дэд захирал гээд хуучин 5 дэд захиралтай байсан бол одоо үндсэндээ Тэргүүн дэд, Дэд гэсэн 2 дэд захиралтай үйл ажиллагаа явуулж байгаа, бусад газар хэлтсийн захирлууд болбол хэвээрээ ажиллаж байгаа гэж ойлгож болно. Гүйлгээтэй холбоотой асуудлыг та энэ хурлын дараа надтай юм уу, манай IT-гийнхантай бас уулзаад таны тэр асуудлыг шийдвэрлэе ээ.

Цэрэнжав, Хувьцаа эзэмшигч: Санал хэлье. Бид бүхэн мэдэж байгаа. Өнөөдөр Монголын хөдөлмөрийн бирж дээр анх удаагаа зэсийн арилжаа явагдаж байна. Одоо удахгүй алтны арилжаа эхэлнэ гэж бодож байна. Тэгээд манай Төрийн банк Голомт, Худалдаа хөгжил, Хаан ч юм уу банкуудтай өрсөлдөх ёстой болов уу гэж бодож байна. Тэгээд бид энэ чиглэлээр үйл ажиллагаагаа тэлээч ээ, мөнгөний урсгал хаана байна, тэнд бид нар тэргүүнд нь явах ёстой. Дандаа сүүлийг нь хамж явах ёсгүй биз дээ. Ийм учраас та нарыг энэ асуудалд дүгнэлт хийгээд ер нь хөрөнгийн зах зээл дээр ялангуяа энэ ашигт малтмалын гүйлгээний үйл ажиллагаанд нэлээн идэвхтэй оролцох ёстой болов уу, гэж бодож байгаа юм. Энд оролцох арга хэмжээ аваарай гэж санал болгож байна аа.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Цэрэнжав гуайдаа баярлалаа. Таны саналыг хүлээж авч байна аа.

Туяа, Хувьцаа эзэмшигч: Ерөнхийдөө бол яах вэ бүгдээрээ мэдэж байгаа. Хувьцааны үнэ жоохон унаж байгаад бол бас зарим хувьцаа эзэмшигчид маань сэтгэл жоохон нэг тийм янз бүр байгаа байх. Үүн дээр ТУЗ-ийн даргын хувьд тайлбар хийлээ гэж би ойлгож байгаа. Олон хувьцаа зах зээл дээр гараад, тэгээд тэр нь тодорхой хэмжээгээр нөлөөллөө гэдэг тайлбарыг болбол өглөө гэж ойлгож байгаа. Тэгэхдээ болбол яах вэ, би бол стратегийн биш энгийн хувьцаа эзэмшигч учраас одоо яг ингээд удаан барих уу, яах вэ гэдгээ хараад явж байгаа. Ямар ч байсан ногдол ашиг нэмэгдээд, хадгаламжаас доошгүй хувийг хэмжээний ногдол ашиг өгч байгаад нь бас талархалтай хүлээж авч байна. За эндээс бол би энийг асуух гээд байгаа юм. Нийт активуудыг хараад байхад болбол 2,3 их наяд зээл байна л даа. Үүнээс гадна 1,2 их наяд нь бодит үнэ цэний өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд

бүртгэгдэх өрийн хэрэглүүр гээд нэлээн том дүнтэй дүн яваад байгаад байгаа байхгүй юу. Энэ одоо яг юу, ямар актив, ямар хөрөнгө байна аа гэдгийг нэг тодруулж өгөөч гэж хүсэх гэсэн юм. Би энийг сайн ойлгоогүй болохоор зэрэг мэдэх гэсэн юм.

Д.Жадамбаа, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал: Эхний асуултад хариулъя, банкны хувьцааны үнэ зах зээл дээр унаж байгаа энэ асуудал дээр. Ер нь болбол үнэн, МХБ дээр гаргасан нийт 5 том банкны, Хаан банкнаас бусад 4 том банкны хувьцааны үнэ бол ерөнхийдөө сүүлийн 1 жилд бол тогтмол бууралттай байгаа. Бидний зүгээс энийг банкны үйл ажиллагаатай холбоотой гэхээс илүү, зах зээлийн нөхцөл байдал богино хугацаанд МХБ дээр өндөр хэмжээний хувьцааны нийлүүлэлт хийгдсэнтэй холбоотой богино хугацааны шок байгаа гэж харж байгаа. Дунд хугацаандаа болон урт хугацаандаа хувьцааны үнэ тогтворжиж буцаад эргээд өсөх ийм боломж байгаа гэж бид бүхэн харж байгаа. 2 дахь асуултад хариулъя. Зээлээс бусад ямар активт хөрөнгөө байршуулж байгаа гэж асуусан байна. Банк болбол ерөнхийдөө татан төвлөрүүлсэн хөрөнгийнхөө 65 орчим хувийг зээлд байршуулдаг, 7-8 хувийг үндсэн хөрөнгөндөө байршуулдаг тэгээд тооцохоор үлдэгдэл 27-28 орчим хувийг болбол Монголбанкны үнэт цаас, Монголбанканд заавал байлгах нөөц, бусад үнэт цаас, нэгжүүд дээр байгаа бэлэн мөнгө гэсэн хэлбэртэй байршуулдаг байгаа.

Туяа, Хувьцаа эзэмшигч: Би бол зүгээр яг тодорхой асуулт асуусан л даа. Тайлан дээр чинь тодорхой байна шүү дээ, 13 дахь нь болбол Монголбанк дахь тэр харилцах, хадгаламж энэ тэр гээд. Би болохоор энэ 18 дугаарх тодруулга гэснийг нь асууж байгаа юм. Бодит үнэ цэний өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр гээд 1,2 их наяд төгрөг байна аа, энэ юу юм бэ гэдгийг л асуух гэсэн юм. Тэрнээс биш тэр бусад өөр юмнууд чинь энд 14, 15, 16 гээд тайлбарууд чинь байж л байна. Яг энэ тодорхой энэ 18-д чинь юу, юу орж байгаа юм бэ л гэж асуусан юм.

Д.Жадамбаа, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал: За асуултад хариулъя. Энэ дотор болбол банк оруулчихсан байгаа хөрөнгө оруулалтуудыг бодит үнэ цэнээр жил болгон бүртгэж явдаг. За хэрэв одоо тухайн өрийн хэрэглүүрийн үнэ өссөн байх юм болбол бодит үнэ цэний одоо нэмэгдүүлэлт байна аа гэж үзээд хөрөнгө талд нь нэмэгдлийг бүртгээд явдаг байгаа, хугацааны эцэст маань энэ бодит үнэ цэний нэмэгдүүлэлт маань одоо ашиг болоод ингээд хувираад явдаг байгаа. Тухайн жилийн ашиг дээрээ тусгагдаад, одоо болбол энэ бусад дэлгэрэнгүй орлого буюу бусад ашиг гэсэн хэсэгт толилуулагдаад ингээд явдаг байгаа. Ямар хөрөнгүүд байгаа вэ, гэдэг дээр одоо бол манайд ЗГ-ын олон улсад гаргасан бондууд байгаа. Энэ маань болбол ойролцоогоор 60 сая орчим доллар буюу 180 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө байгаа. За бусад хувьцаанууд бас байгаа бага хэмжээтэй.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Баярлалаа, асуулт хариултын цаг дууссан байгаа. Цахимаар бас 1 асуулт ирсэн байгаа. Энэ 2 асуултаар асуултаа тасалъя.

Хувьцаа эзэмшигч: Сайн байцгаана уу? 1 дүгээрт, дахиж хувьцаа гаргах ер нь шаардлагатай юу? 2 дугаарт, эрэлт байгаа юм уу, эрэлт үүсгэхийн тулд өгөөж сайн байж байж эрэлт үүснэ ээ дээ, өгөөж бага бол эрэлт үүсгэхгүй л байх гэж харж байна л даа, тэгээд магадгүй хүмүүс итгэл алдраад хямдхан зарж эхлэх үед ер нь юу болох юм бэ? Арай хэдэн

мөнгөтэй хүн нь худалдаж аваад нэг иймэрхүү зүйл үүсэх гээд байгаа юм шиг байх юм.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Асуултад хариулъя. Яг ийм шалтгааны улмаас бид нар бас зах зээлийн судалгаа маш сайн хийж байж, нэмж хугацаа гаргах асуудлыг бол шийдэх ёстой байгаа. За энэ дээр бол нэмж хугацаа гаргах уу, эсвэл одоо байгаа хувьцаагаа санал болгох замаар явах уу, гэдэг ийм шийдвэрүүдийг бол яг энэ зах зээлийн судалгаа, зах зээлийн нөхцөл байдлыг сайн харж байж хийхгүй бол, эргээд банкны үнэлгээ, одоо хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө тул эрсдэл учруулж болохгүй гэдэг ийм байр суурьтай байгаа. Тэгэхээр яг тантай бол санал нэг байна. Бид бол энэ дээр эрэлт үүсгэх ёстой. Үүн дээр товчхон нэмээд хэлэхэд яг энэ Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах боломж, эдийн засгийн нийлүүлэлт, эрэлт талаасаа бол бас бид нар сүүлийн 2 жил бол огцом нэлээн олон нээлттэй хувьцаат компани болох энэ орлогуудыг хийсэн. УИХ-аас бас нэмж маш олон компаниудыг IPO хийхийг бол даалгасан байгаа. Тэгэхээр энэ дээр бол яг зах зээлийн судалгааг ЗГ-ын түвшинд болон тухайн байгууллагуудын түвшинд хийхэд бол зах зээлийн бас тодорхой эрсдэлүүд байна. Компанийн үнэлгээтэй холбоотой эрсдэлүүд байгаа учраас одоо үе шаттай энэ ажлууд явагдаж байгаа. Бид нарын туйлын зорилго бол дор хаяж 20 хувь, цаашлаад 34 хувь, 49 хувь хүртэл нээлттэй компани болох ийм зорилго чиглэлтэй байгаа.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Сүүлийн асуулт, Дашдаваа овогтой Боргио гэж хүнээс ирсэн байна. Банкуудыг эзэмшигч 20 хувь байх ёстой хуулийн хэрэгжилтийг хэзээ хангаж ажиллах вэ? Хууль их ярьж байна, гэсэн байна. Үүн дээр бол Банкны тухай хууль дээр бол 36.1-т аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байна гээд заалт байдаг. Энэ бол 2021 оны 1-р сарын 29-нд орсон өөрчлөлт, гэхдээ 36.2.1-т тусгай зориулалтын банканд бол энэ хязгаарлалт хамаарахгүй гэдэг заалт байгаа. Тэгэхээр бас Монголбанкнаас Төрийн банкыг энэ цаг хугацаанд тусгай зориулалтын банк гэсэн ийм статустайгаар тодорхойлсон байгаа. Гэхдээ бид одоо 5 хувь байгаагаа бол 20 хувь цаашлаад бол нэмэгдүүлэх ийм бодлого чиглэлийг баримтлаад, энэ чиглэлийн судалгаа стратегийн хөрөнгө оруулагч зөвхөн дотоодоос гэхгүй, гадаадын стратегийн хөрөнгө оруулагчдыг бол бас авах чиглэлээр нэлээн идэвхтэй ажиллаж байгаа. Энэ дээр бол дахиад танд болон энэ Боргио гэдэг энэ хөрөнгө оруулагчид хэлсэн энэ эрсдэлүүдийг бид нар сайтар судалж үзэх ёстой.

Хувьцаа эзэмшигч: Санхүүгийн мэргэжлийн хүн биш учраас их хөндий асуулт асууж мэднэ шүү, уучлаарай. Бид нар одоо яах вэ ингээд 1 тэрбум төгрөгөөр хувьцаа авчихсан байя, тэрийгээ одоо барьцаалаад зээл авч болох уу, Төрийн банкнаас? 2 дугаарт, хувьцаа унаад байна, багтаамжгүй болчихсон гээд хүмүүс ярьж байна. Миний бодлоор тэрэндээ гол биш, гаргаж байгаа бүтээгдэхүүн нь сонирхолгүй учраас л тэр үнэ нь унаад байгаа байх гэж бодож байгаа байхгүй юу. Тэгэхээр зүгээр нэг хувьцаа гаргачхаад ангайгаад сууж байхын оронд опцион, фьючер эн тэр гээд гаргах юм бол хэдийг ч бараг 100 хувь гаргасан ч хүмүүс худалдаад авна. Хувьцааны үнэ унахгүй гэж бодож байна.

Ө.Гантөр, Гүйцэтгэх захирал: Төрийн банкны “Зээлийн үйл ажиллагааны журам”, “Зээлийн бодлого” гээд холбогдох бодлого, журам, зааварт болбол хувьцаа барьцаалж зээл олгох талаар бол тусгагдаагүй байгаа. За мэдээж одоо хувьцаа маань өөрөө өдөр болгон, сар болгон, цаг минутаар одоо ханш нь өөрчлөгдөж байдаг, нэг талдаа болбол эрсдэл бүхий ийм бүтээгдэхүүн байгаа. Тэгэхээр зэрэг зээлийн барьцаа хөрөнгө маань өөрөө үнэлгээтэй, өндөр үнэтэй, үнэлгээтэй ийм байж байж эрсдэлгүй байна гэж тооцож байгаа.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Хувьцааны үнэлгээтэй холбоотой бол мэдээж хувьцаа бол яг хөрөнгө оруулагчдын тодорхой өөрсдийнх нь эрсдэл байдаг. Бидний хувьд бол манай банканд итгээд хувьцаа худалдаж авсан, хувьцаагаа ингээд хадгалж байгаа хөрөнгө оруулагчид та бүхэндээ ТУЗ болон Сангийн яамны зүгээс энэ банк бол тогтвортой, найдвартай, яг бизнесийн хувьд бол хамгийн эрсдэл багатай ийм одоо үйл ажиллагаа явуулна. Үүн дээр бол бидний хувьд бас онцлог нь бол төрийн өмчид байдаг. Тэгэхдээ бид нар бас Өрсөлдөөний тухай хуулийн болон Төрийн хэмнэлтийн хуулийн зохицуулалтууд байдаг. Яг та бүхний хэлж байгаа саналууд дээр бол 100 хувь санал нэг байна. Бидний хувьд бол энэ жилээс хөрөнгө оруулагчдын бас илүү мэдээллийг хүргэх, хөрөнгө оруулагч нартаа үйлчилгээгээ үзүүлэх энэ чиглэлийн бас үйл ажиллагааг бол сайжруулах шаардлагатай байгаа. Энэ дээр бол та бүхэнтэй бол санал нэг байгаа. За ногдол ашгийн хувьд ч мөн адил, яг тогтвортой жигд ногдол ашгийн бодлого баримтлаад явна. За та бүхэн өнөөдөр бас заалнаас 2, 3 хүн санал хэлж байна. Энэ өгөөжийн хувьтай холбоотой, энэ өгөөжийн хувийг бид энэ жилээс бас нэлээн анхааръя. Ногдол ашгийн бодлогодоо болон мөн санхүүгийн төлөвлөгөө бодлого боловсруулахдаа бас энэ дээр нэлээн анхаараад явъя. Та бүхний гаргаж байгаа саналтай бол 100 хувь санал байна гэдгээ бас хэлье, Баярлалаа. Асуулт хариултын хугацаа дуусаад өнгөрч байгаа учраас асуулт хариултаа хааж байна. Санал хураах асуудлаар хувьцаа эзэмшигчдийн саналыг авна. 25 минутын санал хураах зайтай цайны завсарлага байгаа юм байна. Одоо 10 цаг 20 минут болж байна, 10 цаг 45 минутад эргэж энэ зааландаа уулзаад санал хураалтын дүнгээ нэгтгэж танилцъя. Та бүхэн санал хураалтанд идэвхтэй оролцоно уу. Цайны завсарлагын үер банкны удирдлагууд болон ТУЗ-ийн гишүүд, банкны ажилтнуудаас сонирхсон асуулт байвал нээлттэй асуугаарай. Түрүүн хувьцаа эзэмшигчийн зүгээс асуусан IT-н холбогдолтой асуулт дээр манай банкнаас очоод бас тайлбарлаад асуудлыг нь газар дээр нь бас шийдэж өгөөрэй гэж хүсэж байна. Цайны завсарлага, санал хураалт эхэллээ.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Цайны завсарлагын хугацаа дуусаж байна. Та бүхэн суудлаа эзэлнэ үү. Хурлын тооллогын комисс санал хураалтыг бид нар танилцуулна.

А.Батмөнх, Тооллогын комиссын дарга: Төрийн банкны хувьцаа эзэмшигч та бүхэн суудлаа эзэлнэ үү. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын газрын тогтоол №2, 2024 оны 4-р сарын 29-ний өдөр, ХК-ийн ХЭХ-аар хэлэлцсэн асуудлын саналыг дүнг нэгтгэн батлах тухай, Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.8 дахь заалт 2024 оны 4-р сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын санал хураалтын дүнг тус тус үндэслэн тогтоох нь: “Төрийн банк” ХК-ийн 2023

оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 94,57 хувийн ирцтэйгээр 99,999 хувиар зөвшөөрсөн санал өгсөн байх тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
714,085,287	99.999 %	4,525	0.001 %	5,527	0.001 %

Тооллогын комиссын дарга А.Батмөнх, гишүүд Ц.Дамдинсүрэн, Д.Жадамбаа, Б.Цэндсүрэн, С.Баярхүү, хурлын нарийн бичгийн дарга Л.Булгаа. Та бүхэн саналын хуудасны ирцийн мэдээллийг дэлгэцээр мөн давхар харуулж байгааг үзнэ үү. Хурлын шийдвэрийг танилцуулж, хурал хаах тухай хурлын асуудлаар ТУЗ-ийн дарга Б.Тэлмүүнд микрофоныг шилжүүлье.

Б.Тэлмүүн, Хурлын дарга: А.Батмөнх захиралд баярлалаа. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол, “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6; 29.2.7 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн 2024 оны 4-р сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн тогтоох нь: 1. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай. 2. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд “Эрнст энд Янга Монголиа Аудит” ХХК-ийн хийж баталгаажуулсан аудитын тайлан, түүний талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрсүгэй. Хурлын дарга Б.Тэлмүүн. /Алх цохив/

Б.Тэлмүүн, Хурлын дарга: Тогтоол батлагдлаа. Үүгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хааж байна. Өнөөдрийн хуралд маань цаг заваа гарган ирж оролцсон мөн цахимаар оролцсон бүх хувьцаа эзэмшигчид, банкны ажилтнууддаа баярлалаа. Энэ жилийн хувьд бид банк өмнөө тавьсан зорилго, санхүүгийн үр дүн, үйл ажиллагааны үр дүнг бол бид нар өмнөх жилийнхээ олсон амжилтыг бол улам бататгана. Өнөөдөр гаргасан саналуудыг бид энэ жилийнхээ үйл ажиллагаанд бас анхаарч тусгаж хэрэгжүүлж явна гэдгийг хэлье. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг амжилттай хэлэлцэж дууслаа. Та бүхэнд баярлалаа. Та бүхэнд эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Хурал хаасныг мэдэгдье. /Алх цохив/

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлав.

2. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголия аудит” ХХК-ийн хийж баталгаажуулсан аудитын тайлан, түүний талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрөв.

ХУРЛЫН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Э.УЯНГА

**“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: _____

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

--	--	--	--	--	--	--	--	--	--

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09 цагт хосолсон /танхим, зайнаас/ хэлбэрээр зохион байгуулагдана.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	“Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл			

2024 оны ... –р сарын ...-ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

Саналын хуудсыг бүртгэж, хүлээж авсан ажилтны гарын үсэг, гарын үсгийн тайлал:

/ _____ /

САНАМЖ

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) тэмдэглэгээг хийнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХК-ийн Төв байр, орон нутаг дахь салбар нэгжүүдээр, цахим хэлбэрээр өгөх бол Төрийн банкны цахим хуудас www.statebank.mn/-аар дамжуулан өгч болно.
3. Хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгсөн бол дахин санал өгөх эрхгүй.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичин өгч нотариатаар баталгаажуулж, итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
5. Засварласан, балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
6. Хэлэлцэх асуудалтай холбогдох асуулт, саналаа арын нүүрэнд бичиж өгнө үү.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцох эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан: _____